

21 АЙМАГ, 9 ДҮҮРГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР-Т

ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМ
CIVIL MOVEMENT PARTY

2020-06-23 № 02/06
танай _____-ны _____

Хүсэлт гаргах тухай

Амар мэнд үү?

Иргэний Хөдөлгөөний нам нь улс эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдлийг бататган бэхжүүлж, аливаа хүний жам ёсны эрх, эрх чөлөө, эрхэмсэг оршихуйг дээдэлж, улс үндэстнийхээ соёл, уламжлалын үнэт зүйлсүүдийг хадгалан хамгаалж, орчин үеийн хөгжил дэвшлийн ололтуудтай уялдуулан хөгжүүлэх замаар нийгмийн дэвшил, нийтийн сайн сайхны төлөө ажилладаг бөгөөд айл өрх, иргэн бүрт өсөн дэвжих адил тэгш боломж, улс төр, эдийн засаг, нийгмийн тэгш шударга оролцоог бий болгох зорилт тавин ажиллаж байна.

Иргэний Хөдөлгөөний нам нь 2016 оны УИХ-ын сонгуулийн өдрөөс хойш өнөөдрийг хүртэл гишүүд, дэмжигчдээсээ намын хандив аваагүй болно.

Намын дотоод зохион байгуулалтын онцлогоос хамаарч, Ерөнхий нарийн бичгийн дарга аймаг, дүүрэг тус бүрд 2020 оны орон нутгийн сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрийг хүргүүлж байна.


Тус намын 2020 оны орон нутгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль”-ийн 37-р зүйлийн 37.1, 37.5, 37.6 дахь заалтын дагуу хянаж, дүгнэлт гаргаж өгнө үү.

Орон нутгийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, санхүүгийн тайланг хавсаргав.

Хувийг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагуудад хүргүүлэв.

ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д. Гүдэгшилт
Аудитор гүйцэтгэх
[Signature]



Иргэний Хөдөлгөөний Намын “ИХ ШТАБ”, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Бага тойруу – 42,
Монголын Залуучуудын Холбооны төв байр 210 тоот тасалгаа
Холбоо барих: 90999989, 89003799, 95961529, 99031777